



**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

додын оны 04 сарын 16 өдөр

Дугаар 228

Улаанбаатар хот

Б.Болор-Эрдэнэд сахилгын
шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.4 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.7, 37.1.13, 37.1.18, 48 дугаар зүйлийн 48.1.2 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7, 17.1.8 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/1716 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 10.1, 10.4, 10.5, 10.7 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Болдын Болор-Эрдэнэ нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль холбогдох бусад хууль тогтоомж, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ зөрчиж ёс зүйн зөрчил гаргасан нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын. Ёс зүйн дэд хорооны 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн "Дүгнэлт" болон өөрийн гаргасан тайлбараар тогтоогдсон тул түүнд 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрөөс нээлттэй сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаанд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, үүрэгт ажлаа ёс зүйтэй гүйцэтгэхийг улсын бүртгэгч Б.Болор-Эрдэнэд үүрэг болгосугай.

3. Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс /Д.Оюунбаяр/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т тус тус даалгасугай.

4. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА

Д.ДЭЛГЭРСАЙХАН



142401150